

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Д.Намсрай *

Ө нөөдрийн нээлттэй эдийн засгийн нөхцөлд дэлхийн хүн амын 1/4 нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хувийг бүтээж энэ хэмжээгээрээ сайн сайхан амьдарч байхад 3/4 нь үлдсэн багаахан баялгийг бүтээж энэ хэмжээгээр ядуу буурай амьдарч байна. Нэг үгээр хэлбэл хүн төрөлхтөн гурав дахь мянганаа асар өндөр хөгжил-баян чинээлэг амьдрал, хөгжлөөр дорой-ядуу буурай байдал гэсэн 2 туйлыг бий болгон угтлаа. Ядуурал, өлсгөлөн, ДОХ, байгаль орчны доройтол: дулаарал, цөлжилт, агаарын бохирдол гээд шийдвэрлэх ёстой асуудлын тоо өссөөр байна. Шинэ мянганы гараан дээр хүн төрөлхтөн нэгдмэл нэгэн хувь заяатай, хөгжлийн нийтлэг ашиг сонирхолтой гэдгээ ухамсарлан түгээмэл зорилгоо тунхаглажээ. 2000 оны есдүгээр сард дэлхийн 189 орны төрийн тэргүүн нар оролцсон НҮБ-ын Дээд хэмжээний уулзалтаар “Мянганы Тунхаглал” хэмээх түүхэн баримт бичгийг баталсан. Энэ баримт бичиг нь 2015 он хүртэл ядуурал, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин, хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийн г.м тулгамдсан асуудлуудыг 8 зорилгын хүрээнд багцалсан дэлхийн улс орон бүрийн Мянганы хөгжлийн үүрэг амлалт байсан юм.

Манай улс Мянганы Тунхаглалд нэгдэн орсноор өөрийн хөгжлийн онцлогоо харгалзан 9 зорилго, 22 зорилтыг тодорхойлж УИХ-аар батлуулан, хэрэгжилтийн талаар 2 жил тутамд дүгнэж байна. Одоогоор Мянганы Хөгжлийн Зорилтууд (МХЗ)-ын хэрэгжилтийн талаарх үндэсний илтгэл 2004, 2007 онуудад боловсруулагдан гарсан бөгөөд эдгээр илтгэл нь манай улсын МХЗ-уудын хэрэгжилтийг дүгнэж, цаашдын арга замыг тодорхойлсон баримт бичиг юм. Үндэсний илтгэлийг боловсруулахад НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газраас “Ядуурал, МХЗ-уудын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог дэмжих” туршилтын төслөөр дамжуулан арга техникийн болон санхүүгийн дэмжлэг тусалцаа үзүүлж байна.

Монгол улсын МХЗ-уудын хэрэгжилтийн талаарх Үндэсний хоёр дахь илтгэлийн нээлтэн дээр НҮБ-ын Суурин зохицуулагч, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгч Пратиба Мета “Монгол улсын Мянганы хөгжлийн 22 зорилт батлагдсанаас одоогоор 60 орчим хувь нь биелэгдэж байгаа болон цаашид 2015 он гэхэд хүрэх боломжтойг тэмдэглэхэд таатай байна”¹ гэж тэмдэглэсэн байна.

Монгол улс Мянганы Тунхаглалд нэгдэн ороод 7 жил өнгөрөхөд хөгжлийн зарим зорилтуудаар амжилт олсон байна. МХЗ-даас хүүхдийн эндэгдлийг бууруулах, эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, хүүхдийн хоол

* МУИС, ОУХС-ийн дэд профессор, доктор (Ph.D)

¹ Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний Илтгэл. Улаанбаатар, 2007

тэжээлийн дуталыг арилгах, ерөнхий боловсрол эзэмшигчдийн дотор охид хөвгүүдийн харьцаа г.м чиглэлээр илүү ахиц гарчээ. Манай улсад нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 16 жилийн хугацаанд эрчимтэй буурсан байна. Энэ чиглэлээр Мянганы хөгжлөөр дэвшүүлсэн зорилтуудыг 2006 оны байдлаар бүрэн хангаад байгаа бөгөөд цаашид ч улам бууруулах боломжтой ажээ. Мөн эхийн эндэгдэл сүүлийн 5 жилд тогтвортой буурчээ. Төвөөс алслагдсан зарим аймгуудад эхийн эндэгдэл илүү байгаа ч “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөр хэрэгжиж, эхийн эндэгдлийг 2000 онтой харьцуулахад 2006 онд 2 илүү дахин бууруулсан байна.

Манай улсад өлсгөлөн байхгүй бөгөөд харин хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Тав хүртэлх насны хүүхдийн хоол, тэжээлийн дутлын дундаж үзүүлэлтээр Ази, Номхон далайн бүс нутгийн зарим орнуудаас илүү түвшинд хүрсэн байна. Гэвч дээрх ололт амжилтын зэрэгцээ МХЗ-уудад хүрэхийн тулд цаашид нилээд хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна. Манай улс МХЗ-уудын хэрэгжилтийг гаргахдаа олон улсад түгээмэл хэрэглэгддэг аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэж байна. УИХ-ын 2005 оны 25-р тогтоолоор Монгол улсын Мянганы хөгжлийн 9 зорилго, 22 зорилтын хүрээнд 24 шалгуур үзүүлэлтийг хэрэглэхээр баталсан. Батлагдсан 24 шалгуур үзүүлэлтээс тавьсан зорилтдоо “эрт хүрсэн” гэсэн үнэлгээг 4 үзүүлэлт, хангах “боломжтой” гэсэн үнэлгээг 10 үзүүлэлт, хэрэгжилт “удаан” гэсэн үнэлгээг 3 үзүүлэлт, өмнө хүрсэн түвшнөөсөө “ухарсан” гэсэн үнэлгээг 7 үзүүлэлт авсан байна. Дээрх үзүүлэлтүүдээс хэрэгжилт нь “удаан” болон өмнөх түвшингээсээ “ухарсан” үнэлгээг авсан үзүүлэлтүүд манай улсын МХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлууд болж байна.

МХЗ-уудын хэрэгжилт “удаан” үзүүлэлтүүдэд ядуурлын түвшин, эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь, дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй эрэгтэйчүүдийн тооны харьцаа зэрэг үзүүлэлтүүд орсон бол өмнө хүрсэн түвшнөөсөө “ухарсан” үзүүлэлтэд бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, нэгдүгээр ангид элсэн ороод 5-р анги хүртэл суралцагсдын хувь, 15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь, ХАА-аас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь, үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь, сүрьеэгээр шинээр өвчлөгсдийн түвшин, ойт нутгийн эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд оржээ. Өмнөх түвшнөөсөө “ухарсан” үзүүлэлтийн тухайд 2015 он гэхэд хэрэгжүүлэх боломж бага байна гэж үндэсний илтгэлд дүгнэжээ. Дээрх байдлаас үзвэл манай улс МХЗ-уудаа амжилттай хэрэгжүүлэхэд хүн амын ядуурал, орон сууцны асуудал, бичиг үсэг тайлагдалтын байдал, жендэрийн тэгш байдал, байгаль орчны хүрээнд тулгамдсан асуудлууд байгаа нь харагдаж байна. Ийм зорилтуудын нэг нь ядуурлыг бууруулах явдал мөн. Ядуу байна гэдэг хүний хөгжлийг доройтуулагч хамгийн нөлөө бүхий үзүүлэлт гэж үздэг. Ийм ч учраас НҮБХХ-өөс боловсруулдаг Хүний хөгжлийн илтгэлд хүний хөгжлийг тодорхойлогч олон үзүүлэлтүүд дотроос үндсэн үзүүлэлтэд “...эрүүл байх, боловсролтой байх, орлоготой байх”² гэж тодорхойлсон байдаг.

Хүний хөгжлийг хангах хамгийн гол хүчин зүйл нь эдийн засгийн өсөлт ба хүний хөгжлийн нягт уялдаа, шууд хамаарлыг хангах явдал мөн. Сүүлийн

² Монголын хүний хөгжлийн илтгэл. Хуудас 7. 2003

жилүүдэд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн, валютын нөөц өндөр өсөлттэй байгаа ч харин хүн амын дотор ядуу иргэдийн эзлэх хувь тогтвортой хадгалагдаж байгаагаас гадна амьдралын түвшний ялгаатай, тэгш бус байдал улам нэмэгдэж байна. Хүн амын орлого нь хүний хөгжлийн хамгийн чухал үзүүлэлт төдийгүй хүн амьд явах, эрх чөлөөгөө эдлэх сонголтоо хийж хөгжих боломжтой байх үндсэн түлхүүр нь юм. Ингэснээрээ хүн эрх чөлөөтэй, хурдацтай хөгждөг жамтай. Нөгөө талаас хүний эрх чөлөө нь “сонголтоо хийх боломжтой байх”-аар илэрдэг гэвэл орлогогүй бол яаж сонголт хийх билээ. Энгийнээр хэлэхэд эрүүл мэндээ хамгаалах, боловсрол олоход сонголт хийх ямар ч боломжгүй. Энэ утгаараа хүний хөгжлийн болон хүний эрхийн чухал хүчин зүйл нь ядуурлыг бууруулах асуудал мөн. Өнөөдөр улсын дунджаар манай гурван хүн тутмын нэг нь Засгийн газраас баталж өгсөн амьжиргааны баталгаажих түвшнөөс доогуур орлоготой ядуу амьдарч байна. Гэтэл Засгийн газраас баталдаг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 108.000 төгрөг, амьжиргааны баталгаат доод хэмжээ нь 73.300 төгрөг байгаа нь амьдралын баталгаа болж чадахгүй байна.

Манай улс МХЗ-уудын хүрээнд ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын эзлэх хувийг 2015 он гэхэд 2 дахин бууруулж 18 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Засгийн газраас ч нийгмийн эмзэг бүлгүүд, хүүхэд залуучуудад зориулсан халамжийн тэтгэврийг нэмэгдүүлэх талаар их ажил хийжээ. “Хүүхдийн мөнгө” хөтөлбөр, “Шинэ төрсөн хүүхэд” хөтөлбөр, “Анх удаа гэрлэгчид” хөтөлбөр, “Үдийн цай” хөтөлбөр, түүнчлэн ядуу болон малчин өрхийн 1 хүүхдийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр, ядуу болон ерөнхий боловсролын сургуульд 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг суралцдаг айл өрхийн 1 хүүхдийн хичээлийн хэрэгслэлийг олгох, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны зардлыг хариуцах гээд олон арга хэмжээ авч байна. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас авч байгаа манай улсын өр зээлийн нилээд хувийг ядууралд зарцуулсан байна. Хуваарилсан салбараар нь аваад үзвэл ядуурал гуравдугаар байр эзэлж байгаа юм. Гэвч Засгийн газраас ядуурлыг бууруулах талаар авсан арга хэмжээ, хэрэгжүүлсэн олон бодлого, хөтөлбөр үр дүнгээ өгч чадсангүй. Манай улсын ядуурлын түвшин 1990-2006 оны хугацаанд дөнгөж 3.9 пунктээр буурч, 32.2 хувьтай байна. Энэ хугацаанд манай улсын хүн ам багагүй өссөн болохоор харин ч ядуу хүний тоо бодит байдалдаа өссөн байна.

Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засаг, хүмүүнлэг ардчилсан нийгэмд шилжих шилжилтийн үед тохиолдож байгаа хүндрэл бэрхшээлүүдийн нэг нь ядуурал юм. Ядуурлыг арилгахад ганцхан улсын төсөв хүрэлцээгүй. Зах зээлийн шинэ нөхцөлд дасан зохицох гэсэн иргэдийн идэвх санаачлага, иргэний нийгмийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааны үр дүнд энэ бэрхшээлийг даван туулна.

МХЗ-уудын дотроос тулгамдаж байгаа өөр нэг асуудал нь хүн амын орон сууцны хангамжийн асуудал байна. Монгол улс 2015 он гэхэд эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч буй хүн амыг 50 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн. Одоогийн байдлаар манай нийт хүн амын дөнгөж тавны нэг нь халаалт, халуун, хүйтэн, бохирын усны шугам сүлжээнд холбогдсон тохилог сууцанд амьдарч байна. Гэр хороололд амьдарч байгаа иргэд төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбогдоогүй, хог хаягдлын боловсон цэггүй

зэрэг нь тэдний амьдралын чанар муу байгааг харуулаад зогсохгүй хотын ахуй орчин, агаар, хөрсний бохирдлын үндсэн шалтгаан болж байна.

Жендэрийн тэгш байдлын талаар дэвшүүлсэн зорилтууд хэрэгжилт тааруу үнэлгээ авсан байна. Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй эрэгтэйчүүдийн тооны харьцаа, ХАА-аас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь, үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдээр дэвшүүлсэн зорилт “удаан”, эсвэл өмнөх хүрсэн амжилтаасаа “ухарсан” ажээ. Дээд боловсрол эзэмшиж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдийн тооны харьцаанд 2000-2003 онд ахиц гарсан ч 2003 оноос хойш өөрчлөлт гарсангүй. Ийм байдлаар цааш үргэлжилбэл 2015 он гэхэд тавьсан зорилтод хүрэхэд бэрхшээл гарч болзошгүй. Мөн саяхан гарсан Сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн квотыг хүчингүй болгосон. Энэ нь улс төрд жендэрийн тэгш байдлыг хангах талаар хүрсэн амжилтаасаа ухарсан хэрэг болсон юм.

Бусад хөгжиж байгаа орнуудтай харьцуулахад Монгол улсад бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлсэн түвшин харьцангуй өндөрт хүрсэн хэдий ч МХЗ-уудын хүрээнд цаашид дэвшүүлсэн зорилтын хувьд тулгамдсан асуудал байсаар байна. Ялангуяа 1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын талаарх зорилт хугацаандаа биелнэ гэдэгт эргэлзэхэд хүргэж байна. Ийм суралцагчдын хувь дорвитой өсөхгүй байгаагийн гол шалтгаан нь 1-3 дугаар ангийн хүүхдийн сургууль завсардалт их байгаатай холбоотой. Мөн 15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь ч өмнөх хүрсэн түвшнөөсөө ухарсан гэдэг үнэлгээг авсан байна. Дээрх асуудлууд нь МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд манай улсад тохиолдож байгаа бэрхшээлүүд гэдгийг үндэсний хоёр дахь илтгэлд дүгнэсэн юм. Дэлхийн олон улс орнууд МХЗ-уудаа тодорхойлж, хэрэгжүүлэх талаар тодорхой амжилтанд хүрч байгаа ч санхүүгийн эх үүсвэрээ тодорхойлох, ялангуяа улсын төсөв, бусад хөрөнгийн эх үүсвэртэй уялдуулах талаар туршлагатай улс орон цөөн байна.

Манай улс МХЗ-уудын хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд МХЗ-уудыг хангах орон тооны бус Дэд хороо, Удирдах Зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Монгол улс МХЗ-уудыг хэрэгжүүлэх хөрөнгийн хэрэгцээний үнэлгээгээ 2006 онд боловсруулсан юм. Үүний тулд холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан ажлын хэсгүүдийг байгуулж, Сангийн яам, салбарын яамд, НҮБХХ-ийн зөвлөх багтай хамтран ажилласан. Ингэхдээ НҮБ-ын Мянганы төслөөс боловсруулсан “МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээ хийх аргачлал”, Таджикстан улсын “МХЗ-уудыг хангах хэрэгцээний үнэлгээг боловсруулсан” туршлагыг судалсны үндсэн дээр өөрийн орны МХЗ-уудыг хангахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээний үнэлгээг гаргажээ. Энэ үнэлгээгээр манай улс МХЗ-уудаа хангахад 2007-2015 онд 16,752.8 тэрбум төгрөг буюу 14.0 орчим тэрбум ам.долларын санхүүгийн хэрэгцээ гарсан байна. МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дотоод болон гадаад эх үүсвэрээр хангахаар тооцсоны дотор жил бүр 500.0 орчим сая ам долларыг гадаад эх үүсвэрээр, үлдсэн хөрөнгийг дотоодын эх үүсвэрээр хангахаар төлөвлөж байна.

Манай улс МХЗ-уудаа амжилттай хэрэгжүүлэхэд дээр дурьдсан тулгамдсан асуудлууд, ялангуяа ард иргэдээ ядуурлаас гаргах, тохилог орон сууцаар хангах явдал юунаас ч чухал байна. Эдгээр асуудлыг шийдэхэд эдийн

засгийн зохицуулалтын механизмыг оновчтой сонгож шийдвэрлэх шаардлагатай байгааг манай улсын эдийн засагт ойрын үед болсон үзэгдлүүд харуулж байна. Өнгөрсөн богино хугацаанд хүн амд халамж үзүүлсэн бэлэн мөнгө тараах, ажиллагсдын цалинг нийгмийн бүтээмжтэй уялдуулалгүй өсгөх, инфляцийг хөөрөгдсөн арилжааны өөгүй байхад үндэслэлгүйгээр нэмэх, арилжааны банкуудын зээлийг орон сууцны нийлүүлэлтийн чадавхитай уялдуулан зохицуулаагүйгээс орон сууцны үнэ огцом өссөн зэрэг сөрөг үзэгдлүүд үүссэн юм. Саяхан Олон улсын Валютын сан (ОУВС)-гаас зохион байгуулсан семинар дээр тус байгууллагаас манай улсын эдийн засгийн байдалд хийсэн дүгнэлтдээ “Өнгөрсөн хугацаанд бий болсон инфляцийн нэг шалтгаан нь үндэслэлгүй цалингийн өсөлт” гэж дүгнэсэн байна. Хамгийн энгийнээр хэлэхэд л төрийн албан хаагчдын цалинг огцом нэмэгдүүлсэн нь бизнесийн хүрээнд ажиллагсдыг цалингаа өсгөх сонирхлыг дагуулж, ингэснээрээ нийгэм бүхэлд нь “бүтээмжтэй уялдаагүй цалингийн өсөлт”-ийг бий болгож инфляцийг хөөрөгдсөн байна. ОУВС-аас манай улсад олон жил дараалан өгсөн зөвлөлгөө саналаас дүгнэхэд цалинг өсгөх ганц үндэслэл бол нийгмийн бүтээмж байх ёстой бөгөөд бусад бүх тохиолдол нь халамжийн мөнгө тараахтай адил билээ.

МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд анхаарах өөр нэг асуудал бол зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн асуудал байна. Сүүлийн жилүүдэд манай улсын экспортын бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдсэний ачаар дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт өндөр, валютын нөөц өссөн байна. Хэдий ийм ч зарим олон улсын байгууллагын хийсэн судалгаагаар манай улс үндэсний орлоготой нь харьцуулахад гадаад өр ихтэй, эрсдэл өндөртэй орны тоонд орсон хэвээр байгаа. Орчин үед хөгжиж байгаа улс орнуудын дотор гадаадаас өр зээл авч хөгжлийн асуудлаа шийдвэрлэхийн оронд өөрийн дотоод боломж нөөцөө зөв ашиглах талаар илүү анхаарах хандлага гарч байна. Хөгжлийн энэ бодлого, шинэ хандлагыг манай улс ч гэсэн анхаарч өөрийн асуудлыг өөрөө шийддэг болох нь зүйтэй. Саяхан ОХУ-д МУ-ын Ерөнхий сайд С. Баяр хийсэн айлчлалын үеэр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр “Гуйна гэдэг гутамшиг, гуйлгана гэдэг гайхамшиг” гэдэг монгол ардын зүйр цэцэн үгийг иш татаж үг хэлсэн нь энэ асуудлыг хөндөн хэлсэн боловуу. Хөгжсөн орнуудын хувьд дэлхийн зах зээл дээр өндөр техник технологи, шинжлэх ухааны нээлт, шинэ бүтээгдэхүүнээр өрсөлддөг бол хөгжиж байгаа орнуудын хувьд дэлхийн зах зээлд өрсөлдөх давуу тал нь дийлэнхдээ байгалийн баялаг, ашигт малтмалаа үр ашигтай ашиглах явдал юм. Нөөц арвинтай, цөөн орд газрыг ашиглаж эцсийн боловсруулалт хийсэн бэлэн бүтээгдэхүүн гаргах нь өгөөж ихтэй байхаас гадна байгаль орчинг бага бохирдуулах боломж өгнө. Мянганы хөгжлийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгэм, нутгийн оршин суугчдын харилцан ойлголцсон бие биеэ дэмжсэн хамтын ажиллагаа юунаас ч чухал болж байна. Иргэдийн зах зээлд дасан зохицох гэсэн бүтээлч ухаалаг үйл ажиллагааг байнга дэмжиж, харин бэлэнчлэх, бэлэглэх, халамжлах тогтолцооноос татгалзах нь зүйтэй.